



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/728

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зооноз өвчин судлалын төвд олон жил үр бүтээлтэй ажиллаж, ард иргэдийнхээ эрүүл мэндийг сахин хамгаалах, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, шинжлэн илрүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай хүргэх үйлсэд хамт олноо манлайлан ажиллаж буй Халдвар судлалын бага эмч Н.Отгонцэцэгийг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Э.Отгонцэцэгт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Зооноз өвчин судлалын төвийн дарга /Б.Баяржаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ